



Дорнод аймгийн Аудитын Газар

Үндэсний Аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ҮАГ-НАГ-/2016/03-НА



Политехник коллеж, МСУТ нь МБСДС-аас ирүүлсэн тэтгэлгийг
олгохдоо холбогдох журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Чойбалсан хот 2016 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймгийн Аудитын
газрын Гүйцэтгэл аудитын
баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул Утас: 70584203

Аудитын менежер
В.Цэнгэлмаа Утас: 70584207

Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Шинжээч М.Ухаанбилэг
Утас: 70584207

2016 оны 9 дүгээр сар
Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70584207
дугаарын утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн
сум, 7-р баг, аймгийн ЗДТГ-
ын 2-р байр, 2 давхар 104
тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Нэг: Сангаас олгогдож буй тэтгэлэг ЗГ-ын
журмаар бүрэн зохицуулагдаж байна.

Хоёр: Сангийн хөрөнгийн төлөвлөлт,
бүрдүүлэлт нь орон нутгийн түвшинд
хийгддэггүй байна.

Гурав: МБСДС-аас олгогдож буй тэтгэлгийг
холбогдох журмын дагуу зарцуулаагүй
байна.

Дөрөв: Тайлант онд МБСДС-гаас Дорнод
аймагт олгогдсон тэтгэлэгт дотоод хяналт
хийгдээгүй байна.

ДҮГНЭЛТ**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ****ЗӨВЛӨМЖ****АКТ****АЛБАН ШААРДЛАГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ болон Дорнод аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд тодорхойлсон “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гийн үйл ажиллагаа, тус сангаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх;
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.

Аудитын хамрах хүрээ

Дорнод аймгийн Политехник коллеж болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв хамрагдлаа.

Үндсэн мэдээлэл:

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас 2015 онд Дорнод аймаг дахь Политехник коллеж болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2015 онд нийт 320,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС, Нийцлийн аудитын 4000-4200 дугаар стандарт, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, судалгаа авах, зарцуулалтын нөхцөл байдал, үр дүнд шинжилгээ хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудит хийж буй асуудлуудыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- Тэтгэлэг олгох суралцагчдын тоог багшийн цагийн бүртгэлтэй тулган үнэн зөв тооцсон эсэхийг шалгалаа.

- Тэтгэлгийг журмын шаардлагад нийцсэн суралцагчдад олгосон эсэхийг үзлээ.
- Суралцагчдад олгох тэтгэлгийг бүрэн олгосон эсэхийг шалгаж үзлээ.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аймгийн Аудитын газрын гүйцэтгэлийн багийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа, шинжээч М.Ухаанбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2016 оны 08 дугаар сарын 22-оос эхэлж, 09 дүгээр сарын 27-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторoor хянуулан баталгаажуулж, 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдөр ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж, акт болон тайлангийн хавсралт хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

Аудит хийхэд учирсан бэрхшээл:

Аудитын явцад хүндрэлтэй асуудал үүсээгүй болно.

I Бүлэг: Сангаас олгогдож буй тэтгэлэг ЗГ-ын журмаар бүрэн зохицуулагдаж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжигдэж байгаа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон Политехник коллежийн суралцагчдад олгогдож буй тэтгэлэг нь Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, ЗГ-ын 2007

оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”, ЗГ-ын 2011 оны 117 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, ЗГ-ын 2015 оны 477 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох тухай журам”-уудаар тус тус зохицуулагдаж байгаа бөгөөд уг хууль журмаар зохицуулагдахгүй асуудал байхгүй байна.

II Бүлэг: Сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт нь орон нутгийн түвшинд хийгддэггүй байна.

Сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт нь ЗГ-ын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан “МБСДС-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-аар зохицуулагддаг байна. Энэхүү журмын сангийн хөрөнгийг төлөвлөж, бүрдүүлэх хэсэгт “Сангийн хөрөнгө нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20.3, 22.1-д заасан эх үүсвэр болон ЗГ-ын захиалгат төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээс бүрдэнэ” гэж заасны төлөвлөлт, бүрдүүлэлт нь орон нутгийн түвшинд хийгддэггүй байна.

III Бүлэг: МБСДС-аас олгогдож буй тэтгэлгийг холбогдох журмын дагуу зарцуулаагүй байна.

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас Дорнод Политехник коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2015 онд нийт 310,3 сая төгрөгийн тэтгэлэг олгожээ. Үүнээс: Политехник коллеж 712, МСҮТ 328 суралцагч уг тэтгэлэгт хамрагдсан байна.

Тэтгэлгийг холбогдох журмын дагуу олгосон эсэхийг тулгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.

Политехник коллеж:

Политехник коллеж нь 2015 онд нийт 24-өөс дээш насны 6 суралцагчид нийт 1686,2 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1 дүгээр заалттай нийцэхгүй байна.

Мөн 2015 онд хичээлдээ суугаагүй 7 оюутанд 439,4 мянган төгрөгийн тэтгэлгийг олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр заалттай нийцэхгүй байна.

Тус коллежийн дансанд 2015 оны суралцагчдын тэтгэлгийн зөрүү 12739,3 мянган төгрөгийн үлдэгдлээс 2237,3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 10501,9 мянган төгрөгийг сургуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 9 дүгээр заалттай нийцэхгүй байна.

Хөдөлмөрийн яамны МБСДС-гаас Политехник коллежид e-TVET онлайн програм худалдан авах 10000,0 мянган төгрөг олгосны дагуу 2015 оны жилийн

эцэст бүх багш, ажилтнууд болон суралцагчдын мэдээллийг бүртгүүлж коджуулан ажилласан байна.

МСҮТ:

2015 онд багшийн ирцийн мэдээнд бүртгэгдээгүй буюу хичээлдээ суугаагүй суралцагчдад нийт 323,2 мянган төгрөгийн тэтгэлгийг олгосон байна. Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 4 дэх “Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Мөн 2016 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 75 хувийн ирцдээ хүрээгүй нийт 287 оюутны мэдээг тэтгэлэг олгуулахаар явуулжээ. Энэ нь 477 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.2.2. дахь “хүндэтгэн үзэх шалтгаантайгаас /эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт/ бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

IV Бүлэг: Тайлант онд МБСДС-гаас Дорнод аймагт олгогдсон тэтгэлэгт дотоод хяналт хийгдээгүй байна.

МУ-ын ЗГ-ын 2011 оны 117 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.3.т Үндэсний зөвлөл, боловсрол, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага журмын хэрэгжилтэд хяналт тавихаар заажээ. Гэвч тайланд хугацаанд дээрх байгууллагуудаас хяналт хийгдээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сангаас олгогдож буй тэтгэлэг ЗГ-ын журмаар бүрэн зохицуулагдаж байна.
2. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт нь орон нутгийн түвшинд хийгддэггүй байна.
3. МБСДС-гаас олгогдож буй тэтгэлгийг холбогдох журмын дагуу зарцуулаагүй байна.
4. Тайлант онд МБСДС-гаас Дорнод аймагт олгогдсон тэтгэлэгт дотоод хяналт хийгдээгүй байна.

Аудитаар нийт 12950,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, Политехник коллежид 10501,9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2125,6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, МСҮТ-д 323,2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгөв.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ Утас/факс: 7058-4895, http://www.doric.mn 2016.09.28 № 137 танай -ны № -т	ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА	МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ ДОРНОД АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛДЭВЭРЭЛЛИЙН ТӨВ 2016.09.28 № 433 танай -ны № -т	ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Б.БОЛОРТУУЛ ТАНАА
Хүсэлт гаргах тухай Тус сургуулийн суралцагчдад Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас олгож буй тэтгэмжийн санхүүжилтийн гүйцэтгэлд танай газраас хийгдсэн аудитын шалгалтын тайлангийн актуудын төсөлд тусгагдсан дүгнэлттэй танилцаж дараах хүсэлтийг гаргаж байна. Үүнд 2015 онд суралцагчдад олгогдоогүй үлдсэн 10.5 сая төгрөгийг /2015 оны жилийн эцэс улсын төсвийн хүндрэлээс сургуулийн хичээл сургалтын зардалд 88.4 сая төгрөг зарцуулах төлөвлөгөөтэйгээс 43.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгдэж зарим төлбөр төлөгдөж чадахгүй өртэй гарах болсон учир/ сургалтын үйл ажиллагааны зардалд зарцуулсан байгаа үүнийг төсөвт төвлөрүүлэхээр заасан байна. Одоо манай сургуулийн уг 070037403 тоот дансанд ийм хэмжээний мөнгө гаргах үлдэгдэл байхгүй мөн энэ онд сургуулийн төсвийн ихэнх зардлууд 2016 оны төсвийн хуваарьт тусгагдсан орж ирэх зардлаасаа танагдаж байгаа тул энэ төлбөрийг төлж чадахгүйд хүрээд байна. Иймд энэ актын төсөлд тусгагдсан уг төлбөрийг чөлөөлж өгнө үү. Бид цаашид ийм зөрчил гаргахгүй ажиллах болно. Бусад актанд дурьдсан төлбөрийг барагдуулж төсөвт төвлөрүүлэх болно.		Тайлбар хүргүүлэх тухай Тус сургууль 2015-2016 онд Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас ирсэн санхүүжилтийн гүйцэтгэлд аудит хийгдэж байгаа билээ. Аудитаар илэрсэн асуулгын бүртгэл дэх 6.0 сая төгрөгийн зарцуулалтын хариу тайлбарыг хүргүүлж байна. Үүнд: Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 17.1.1 дахь заалтад заасан сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэгсэлдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах гэсэн заалт болон бусад журам, дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан. Суралцагчдын санаачилгаар оюутны үнэмлэхтэй болох, ангиа засварлах, сургуулиас олгосон дадлагын хувьцаанаас гадна уралдаан тэмцээнд оролцохдоо өнгө, загвар өөр хувцасаар жигдрэх гэсэн тус тус саналыг ангийн багш болон анги хамт олноороо хэлэлцэж шийдвэр гаргасныг сургуулийн захиргаанаас дэмжих мөнхийг суралцагчдын тэтгэлгээс суутгаж холбогдох байгууллагуудад шилжүүлсэн. Жишээ: 1. Тэмцээний хувцасыг бичиг баримтан дээр ажлын хувцас гэж буруу тусгасан. 2. Тэтгэлэгийн санхүүжилт хугацаандаа ирэхгүй хоёроос гурван сараар хоцорч ирсэн шалтгаанаас болж суралцагчдын өмнөөс байгууллага тус материалуудыг эзэлээр авч өгч байсан. Суралцагчдын эрүүл мэндийн даатгалыг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Нийгмийн даатгалын хэлтэстэй гэрээ байгуулж гэрээний дагуу тэтгэлгээс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутгаж нийгмийн даатгалын хэлтсийн дансанд шилжүүлсэн.	
ЗАХИРАЛ - С. ДОНООКАРГАЛ		ЗАХИРАЛ - Т.ГАНТУЛГА	

2016.09.28-ны өдөр № 137
Хөтлөх хэрэг № 02

D: /My document/Alban bichig/-2016

21 048

Дорнод аймгийн Аудитын газрын тайлбар:

Тайлбар 1

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2016.09.28-ны өдрийн 137 дугаартай албан хүсэлтийг судалж үзэж, дахин тодруулж МУЕА-ын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 4.1.3 дахь заалтын дагуу албан шаардлага өгөхөөр тогтов.

Тайлбар 2

Дорнод аймаг дахь МСҮТ-ийн 2016.09.26-ны өдрийн 133 дугаартай албан тайлбарыг судалж үзэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Иргэний эрүүл мэндийн

даатгалын тухай хуулийн 6.1.4, 8.2.2 дахь заалт, оюутны үнэмлэх, анги засвар, ажлын хувцас зэргийг суралцагчидтай уулзаж тодруулахад оюутны зөвлөлөөс уриалга гарган нийт оюутнууд дэмжиж тэтгэлгээс суутгуулсан байна. Иймд дээрх тайлбарыг хүлээн авч зөрчлийг тайлангаас хасав.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирал Д.Энхжаргал, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Т.Гантулга нарт:

1. Суралцагчдад тэтгэлгийг олгохдоо Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журмыг мөрдөж ажиллах.
2. Аудитаар тавигдсан төлбөрийн актыг заасан хугацаанд барагдуулж ажиллах.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 22

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаал, 2003 оны 53 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах тухай журам"-ын 4.2 дахь заалт, аймгийн Аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн /"Байгаль хамгаалах сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан"/, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангуудыг баталсугай.

2. Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Алтанзул, аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мөнхсайхан, Политехник коллежийн захирал Д.Энхжаргал, МСҮТ-ийн захирал Т.Гантулга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер В.Цэнгэлмаад даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

11 166

2016.10.07

Аймгийн Тэргүүлэх аудиторын 2016 оны 10 дугаар
сарын 07 өдрийн хэргийн хяналтын хавсралт



Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Төлбөрийн актын утга	Мөнгөн дүн
1	Политехник коллеж	ҮАГ-НАГ/2016/03-НА	Насны хязгаар давсан суралцагчдад тэтгэлэг олгосон	1,686,210
2	Политехник коллеж	ҮАГ-НАГ/2016/03-НА	Хичээлдээ суугаагүй суралцагчдад тэтгэлэг олгосон	439,444
3	МСҮТ	ҮАГ-НАГ/2016/03-НА	Хичээлдээ суугаагүй суралцагчдад тэтгэлэг олгосон	323,273
Дүн				2,448,927

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн
1	Политехник коллеж	ҮАГ-НАГ/2016/03-НА	Журам мөрдөж ажиллах	10,501,967
2	Аймгийн ИТХ	ҮАГ-НАГ/2016/05-НА	Хууль, журам мөрдүүлэх тухай	-
3	Баян-Уул сумын Засаг дарга	ҮАГ-НАГ/2016/05-НА	Журам мөрдүүлэх тухай	-
Дүн				10,501,967

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.
АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БОЛОРТУУЛ
В.ЦЭНГЭЛМАА

АХЛАХ АУДИТОР

БИМСЭН:

Б.ДЭЛГЭРМАА

ШИНЖЭЭЧ:

М.УХААНБИЛЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2016.10.03 № 01/26 ЯАГ-НАГ/2016/03-НА

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ Д.ЭНХЖАРГАЛ
ТАНАА

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 2015 онд 24-өөс дээш насны 6 суралцагчид нийт 1686,2 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам"-ын 1 дэх "Өмчийн хэлбэр харгалзахгүй мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн сургалт эрхэлдэг байгууллага (цаашид "сургууль" гэх)-д мэргэжлийн анхан, дунд шатны сургалтаар мэргэжил эзэмших 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгоход энэхүү журмыг баримтална." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.", 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай", 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 24-өөс дээш насны суралцагчдад олгосон 1'686'210 (Нэг сая зургаан зуун наян зургаан мянга хоёр зуун арван) төгрөгийг Дорнод аймгийн Аудитын газрын Төрийн сан дахь 070024401 дүгээр дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2016 оны 11 сарын 30-ны дотор Дорнод аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирал Д.Энхжаргал, нягтлан бодогч Г.Гантуяа нарт хариуцуулав.

ТОГТООСОН


АХЛАХ АУДИТОР... Б.ДЭЛГЭРМАА

АКТЫГ


ЗӨВШӨӨРСӨН

ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ... Д.ЭНХЖАРГАЛ

11 306

ШИНЖЭЭЧ  М.УХААНБИЛЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

 Г.ГАНТУЯА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2016.10.03 № 0297-ҮАГ-НАГ/2016/03-НА

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 2015 онд хичээлдээ суугаагүй буюу багшийн цагийн бүртгэлд бүртгэгдээгүй 7 суралцагчид нийт 439,4 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам"-ын 4 дэх "Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.", 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай", 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "....дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дорнод аймаг дахь Политехник коллеж нь хичээлдээ суугаагүй суралцагчдад олгосон тэтгэлэгийн 439'444 (Дөрвөн зуун гучин есөн мянга дөрвөн зуун дөчин дөрвөн) төгрөгийг Дорнод аймгийн Аудитын газрын Төрийн сан дахь 070024401 дүгээр дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2016 оны 11 сарын 30-ны дотор Дорнод аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирал Д.Энхжаргал, нягтлан бодогч Г.Гантуяа нарт хариуцуулав.

АКТЫГ

11 310

ТОГТООСОН¹	ЗӨВШӨӨРСӨН
АХЛАХ АУДИТОР Б.ДЭЛГЭРМАА	ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ШИНЖЭЭЧ М.УХААНБИЛЭГ	ЗАХИРАЛ Д.ОЙХЖАРГАЛ
	НЯРТЛАН БОДОГЧ
	 Г.ГАНТУЯА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2016.10.03. № 01/21 УАГ-НАГ/2016/03-НА

танай _____-ны № _____-т

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Т.ГАНТУЛГА ТАНАА

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2015 онд хичээлдээ суугаагүй буюу багшийн цагийн бүртгэлд бүртгэгдээгүй 3 суралцагчид нийт 323,2 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам"-ын 4 дүгээр "Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.", 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай", 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь хичээлдээ суугаагүй суралцагчдад олгосон 323,273 (Гурван зуун хорин гурван мянга хоёр зуун далан гурван) төгрөгийг Дорнод аймгийн Аудитын газрын Төрийн сан дахь 070024401 дүгээр дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2016 оны 11 сарын 30-ны дотор Дорнод аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Т.Гантулга, нягтлан бодогч Г.Болортуяа нарт хариуцуулав.

АКТЫГ

11 308

ТОГТООСОН¹
АХЛАХ АУДИТОР Б.ДЭЛГЭРМАА
ШИНЖЭЭЧ М.УХААНБИЛЭГ

ЗӨВШӨӨРСӨН
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Т.ГАНТУЛГА
НЯГТЛАН БОДОГЧ
..... Г.БОЛОРТУЯА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7 дугаар баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2016.10.03 № 01/447 УАГ-НАГ/2016/03-НА
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Г ЖУРАМ МӨРДҮҮЛЭХ ТУХАЙ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн"-д нийцлийн аудитыг хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймаг дахь Политехник коллеж нь суралцагчдын 2015 оны тэтгэлгийн үлдэгдэл болох 10501,9 мянган төгрөгийг сургуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэ нь ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам"-ын 9 дэх "Суралцаж байгаа хүний тооноос хамааран санхүүжилтийн хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд зөрүүг төсөвт буцаан төвлөрүүлэх, ..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.", 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай", 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх, дээрх зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Политехник коллежийн захирал Д.Энхжаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН²:

АХЛАХ АУДИТОР

Б. ДЭЛГЭРМАА

ШИНЖЭЭЧ

М. УХААНБИЛЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Д. ЭНХЖАРГАЛ

^{2 2} Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." Гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.